



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/92

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан томилолтоор ажиллуулах журам"-ын 2.1, 3.1, 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Архангай аймгийн дулааны станцын асуудлаар санал, зөвлөмж боловсруулах, газар дээр нь ажиллах зорилгоор Эрчим хүчний сайдын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/223 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн Т.Мөнхбаяр нарыг Архангай аймагт 2023 оны 11 дүгээр сарын 16-18-ны өдөр албан томилолтоор ажиллуулсугай.

2.Албан томилолтоор ажиллах удирдамжийг 1 дүгээр, зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Албан томилолтын тайланг ажлын 3 өдөрт багтаан танилцуулахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн Т.Мөнхбаяр нарт даалгасугай.

4.Албан хаагчдын унаа, томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Отгонтуяа/-д зөвшөөрсүгэй.


ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013730

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын
15 өдрийн А/22 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



УДИРДАМЖ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Албан томилолтын ажлын зорилго, чиглэл:

Эрчим хүчний сайдын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/223 дугаар тушаалаар батлагдсан Архангай аймгийн дулааны станцын асуудлаар санал, зөвлөмж боловсруулах, газар дээр нь ажиллах

Албан томилолтоор ажиллах хугацаа:

2023 оны 11 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд хуанлийн 3 хоногийн хугацаанд гүйцэтгэнэ.

Албан томилолтоор ажиллах газар:

Архангай аймаг

Эрчим хүчний сайдын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/223 дугаар тушаалаар батлагдсан Архангай аймгийн дулааны станцын асуудлаар санал, зөвлөмж боловсруулах, газар дээр нь ажиллах.

.....000.....

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын
15. өдрийн А/а дугаар тушаалын 2 дугаар хавсралт



Орон нутагт томилолтоор ажиллах зардлын төсөв

№	Чиглэл	Тоо	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /төг/	Хянасан
1	Томилолтын зардал	3	хоног	118,000.00x3	354,000.00x2	708,000.00
Нийт зардал						708,000.00

Тоогоор /708,000.00 төгрөг, үсгээр /долоон зуун найман мянга/ төгрөг.

Тайлбар: Сангийн сайдын 2022 оны 120 тоот тушаалаар батлагдсан томилолтын зардлын нормативыг үндэслэн тооцов.

.....000.....